

Дагалдах хэрэгслийн хязгаарлагдмал баталгаа

Үйлдвэрлэгч Research In Motion Limited (“RIM”) компани ба түүний салбар Centrum House, 36 Station Road, Egham, Surrey, UK, TW20 9LF хэмээх хаягаар бүртгэгдсэн, эцсийн хэрэглэгч, Танд (цаашид “Та” гэх) BlackBerry Wireless Handheld-ийн дагалдах хэрэгсэл нийлүүлэгч (цаашид “Дагалдах хэрэгсэл” гэх) нийлүүлэгч Research In Motion UK Limited, Компанийн бүртгэлийн дугаар 4022422, компани тус Дагалдах хэрэгсэл нь (а) Та Дагалдах хэрэгслийг анхных нь эцсийн хэрэглэгчийн хувьд анх худалдан авсан өдрөөс хойш нэг (1) жилээс бага хугацаанд ба/буюу, (b): (1) RIM, Та хоёрын хооронд байгуулсан BlackBerry Эцсийн хэрэглэгч/Програм хангамжийн лицензийн гэрээг (цаашид “Лицензийн гэрээ” гэх) Та зөрчих буюу цуцлах, эсвэл (2) Та энэхүү (i) хязгаарлагдмал баталгаа, (ii) BlackBerry Handheld-тай хамт ирсэн хязгаарлагдмал баталгаа, (iii) BlackBerry-ийн аливаа дагалдах хэрэгсэл буюу гадна зайтай хамт ирсэн аливаа хязгаарлагдмал баталгаа, эсвэл (iv) энэ Дагалдах хэрэгсэл ба/буюу BlackBerry Handheld-тай хамт ирсэн аюулгүй байдлын мэдээллийг зөрчсөнөөр дуусгавар болох хугацааны турш (цаашид “Баталгаат хугацаа” гэх) хийц, материалын ямар нэгэн гэмтэл согоггүй байна гэсэн баталгаа Танд өгч байна. Энэхүү хязгаарлагдмал баталгааг шилжүүлж болохгүй. RIM өөрийн сонголтоор Баталгаат хугацааны турш Дагалдах хэрэгслийг эд анги буюу хөдөлмөрийн төлөө Танаас төлбөр авалгүйгээр засварлах буюу сольж өгнө Хэрэв Баталгаат хугацаанд Дагалдах хэрэгслийг засварлах буюу соливол, засварласан буюу сольсон өдрөөс хойш 91 дэх хоногт буюу анх худалдан авсан огнооноос хойш нэг жилийн дараа Баталгаат хугацаа дуусна. RIM ба Таны Зай ба/буюу BlackBerry шийдлээ дамжуулан худалдан авсан дамжуулан борлуулагч буюу дистрибьюторын (цаашид “RIM шийдэл нийлүүлэгч” гэх) хоорондох гэрээн дээр үндэслэн энэхүү хязгаарлагдмал баталгааг баталгаат хугацааны турш RIM буюу RIM шийдэл нийлүүлэгчийн аль аль нь даган мөрдөх ёстой. Энэхүү хязгаарлагдмал баталгаа нь Дагалдах хэрэгслийн ердийн элэгдэлд хамаарахгүй бөгөөд хэрэв Дагалдах хэрэгсэл буюу түүний аль нэг бүрэлдхүүн хэсгийг RIM-ийн албан ёсны зөвшөөрөлгүй хэн нэгэн задлах буюу зассан тохиолдолд, буруу ашиглах, чийг буюу шингэн, дулааны эх үүсвэрт ойрхон байх буюу хавьтах, осол, зүй бусаар ашиглах, хайхрамжгүй байх, буруу хэрэглэх зэргээс болж гэмтсэн Дагалдах хэрэгслийг засварлах буюу сольж өгөхгүй, бөгөөд RIM-ээс өөр аль нэг этгээдийн хийсэн засвар, өөрчлөлтийн улмаас учирсан гэмтэл согогийг хамрахгүй. Хязгаарлагдмал баталгаа нь Дагалдах хэрэгслийн гадаргууд учирсан физик гэмтлийг хамрахгүй. Хязгаарлагдмал баталгаа нь Дагалдах хэрэгслээс өөр аль нэгэн төхөөрөмжид үйлчлэхгүй. Дагалдах хэрэгслийг RIM-ээс илэрхий сайшаагаагүй буюу нийлүүлээгүй дагалдах хэрэгсэл, бүтээгдхүүн, үйлчилгээ, нэмэлт буюу захын төхөөрөмжийн хамт хэрэглэснээс болж буруу ажиллах, энэхүү буруу ажиллагаа нь Дагалдах хэрэгслийн өөрийнх нь гэмтэл согогтой холбоогүй болохыг RIM тогтоосон нөхцөлд энэхүү хязгаарлагдмал баталгаа үйлчлэхгүй. Үүний зэрэгцээ, хэрэв Дагалдах хэрэгсэлтэй хамт ирсэн буюу BlackBerry Handheld, BlackBerry-ийн аливаа дагалдах хэрэгслийг бүрдүүлэгч BlackBerry шийдлийн аль нэг бүрэлдхүүн хэсэг, түүний дотор гадна зай, SIM карт, BlackBerry Desktop програм хангамж, холбогдох утасгүй өгөгдлийн үйлчилгээ ба баримт бичгийн (цаашид “BlackBerry шийдэл” гэх) хамт ирсэн аюулгүй байдлын мэдээллийг хэрэглэгч дагаж мөрдөөгүйгээс шалтгаалж ийнхүү буруу ажиллавал, хязгаарлагдмал баталгаа хүчингүй болох бөгөөд хэрэв хүчингүй биш байвал үйлчлэхгүй. **Үйлчлүүлэгчийн хувиар Дагалдах хэрэгсэлдээ тусламж дэмжлэг хэрхэн авах талаар зааварчилгаа авахын тулд Дагалдах хэрэгсэлтэй хамт ирсэн бичиг баримтыг үзнэ үү.**

ЭНД ЗААСАНЧЛАН ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙГ ЗАСВАРЛАХ БУЮУ СОЛИХ НЬ ТАНД ҮЗҮҮЛЖ БУЙ ЗАСАХ ОНЦГОЙ АРГА ХЭМЖЭЭ ЮМ. ЭНЭХҮҮ ХЯЗГААРЛАГДМАЛ БАТАЛГАА НЬ ШУУД БУЮУ ШУУД БУС БУСАД БҮХ МЭДЭГДЭЛ, БАТАЛГАА, БАТЛАМЖ, БАТЛАМЖ БИЧИГ, НӨХЦӨЛ, ҮҮНИЙ ДОТОР АЛИВАА БАТАЛГАА, НӨХЦӨЛ, МЭДЭГДЭЛ, БАТЛАМЖ, ТАВААРЫН БАТАЛГАА, ТАВААРЫН ЧАНАР, ХАНГАЛТТАЙ ЧАНАР, ТОДОРХОЙ ХЭРЭГЛЭЭ БУЮУ ЗОРИУЛАЛТАД ТААРАХ БАЙДАЛ, ӨМЧИЙН ЭРХ, ЗӨРЧИЛГҮЙ БАЙДАЛ, ХУУЛЬ БУЮУ ЗАН ЗАНШИЛ, ХЭЛЦЛИЙН ЯВЦ, ХУДАЛДААНЫ ХЭРЭГЛЭЭНЭЭС ҮҮДЭН ГАРАХ БУСАД ЗҮЙЛИЙН ОРОНД ХЭРЭГЛЭГДЭНЭ. RIM БУЮУ RIM ШИЙДЭЛ НИЙЛҮҮЛЭГЧ АЛИВАА ЭТГЭЭДИЙН АЛЬ НЬ Ч ТАНЫ ӨМНӨ ЯМАР НЭГЭН

БАЙДЛААР ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ БӨГӨӨД ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ БУЮУ АЖИЛЛАГААНААС ҮҮДСЭН БУЮУ ТЭДГЭЭРТЭЙ ХОЛБООТОЙ ШУУД БУС, ЭДИЙН ЗАСГИЙН, ТУСГАЙ, АРИЛЖААНЫ, ТОХИОЛДЛЫН, ЖИШИГ БУЮУ ҮР ДАГАВРЫН ШИНЖТЭЙ ХОХИРОЛ (ҮҮНИЙ ДОТОР АЛДАГДСАН АШИГ, БИЗНЕСИЙН ОРЛОГО БУЮУ АШГИЙН АЛДАГДАЛ, АЛДАГДСАН ӨГӨГДӨЛ, ТӨЛӨВЛӨСӨН ХАДГАЛАМЖИЙГ БИЙ БОЛГОХ ХУГАЦАА АЛДСАНААС БУЮУ ИЙМ ХАДГАЛАМЖ БИЙ БОЛГОЖ ЧАДААГҮЙГЭЭС БОЛЖ УЧИРСАН ХОХИРОЛ), ГАРАХ БОЛОМЖТОЙГ RIM БУЮУ RIM ШИЙДЭЛ НИЙЛҮҮЛЭГЧ МЭДЭЖ БАЙСАН Ч ГЭСЭН ЭДГЭЭР ХОХИРЛЫГ НЭХЭМЖЛЭХ ЭРХЭЭСЭЭ ТА ҮҮГЭЭР ТАТГАЛЗАЖ БАЙНА. ЭНЭХҮҮ ХЯЗГААРЛАЛТ НЬ ЭДГЭЭР ХОХИРЛЫГ ГЭМ ХОР (ҮҮНИЙ ДОТОР ХАЙХРАМЖГҮЙ БАЙДЛЫН УЛМААС УЧИРСАН ГЭМ ХОР) АРИЛГАХ НЭХЭМЖЛЭЛ БУЮУ ЗАРГААР, ГЭРЭЭ, БАТАЛГААНЫ ДАГУУ, БУСАД АЛИВАА ХУУЛИЙН ДАГУУ БУЮУ ХУУЛИЙН АЖИЛЛАГААНЫ АЛИВАА ХЭЛБЭРЭЭР НЭХЭМЖИЛСЭН, БАТАЛСАН, БУЮУ МЭДҮҮЛСЭН ЭСЭХЭЭС ҮЛ ХАМААРАН ХЭРЭГЖИНЭ. ЯМАР Ч ТОХИОЛДОЛД ТАНЫ ӨМНӨ ЭСВЭЛ ТАНААР ДАМЖУУЛАН ЭСВЭЛ ТАНЫ НЭРИЙН ӨМНӨӨС ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ RIM-ИЙН ХАРИУЦЛАГА ТАНЫ ХУДАЛДАН АВСАН ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ҮНЭ БУЮУ ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙГ ЗАСВАРЛАХ БУЮУ СОЛИХ ЗАРДЛЫН АЛЬ ИЛҮҮ ДҮНГЭЭС ХЭТРЭХ ЁСГҮЙ. ЭРГЭЛЗЭЭ ТӨРҮҮЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙХИЙН ТУЛД ЭНЭХҮҮ БАТАЛГААНЫ ЯМАР Ч ЗААЛТ RIM, ТҮҮНИЙ АЖИЛТНУУД БУЮУ ТӨЛӨӨЛӨГЧИД, ЭСВЭЛ ИЙМ RIM ШИЙДЭЛ НИЙЛҮҮЛЭГЧИЙН ХАЙХРАМЖГҮЙ БАЙДЛААС ШАЛТГААЛАН АМЬ НАСАА АЛДАХ БУЮУ ГЭМТЭЛ УЧИРСНЫ ТӨЛӨӨ RIM БУЮУ АЛИВАА RIM ШИЙДЭЛ НИЙЛҮҮЛЭГЧИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГЫГ ХАСАХ БУЮУ ХЯЗГААРЛАХ ЁСГҮЙ.

ЭНЭХҮҮ ХЯЗГААРЛАГДМАЛ БАТАЛГАА НЬ ТАНД ХУУЛЬ ЗҮЙН ТОДОРХОЙ ЭРХҮҮДИЙГ ОЛГОЖ БАЙГАА БӨГӨӨД ТУХАЙН УЛСААС ХАМААРАН ТА МӨН ӨӨР БУСАД ЭРХҮҮДИЙГ ЭДЭЛЖ БОЛНО. ЗАРИМ УЛСУУД ТОХИОЛДЛЫН БУЮУ ҮР ДАГАВРЫН ШИНЖТЭЙ ХОХИРЛЫГ ХАСАХ БУЮУ ХЯЗГААРЛАХЫГ ЗӨВШӨӨРДӨГГҮЙ, ШУУД БУС БАТАЛГАА БУЮУ НӨХЦӨЛИЙН ХУГАЦААГ ХЯЗГААРЛАХЫГ ЗӨВШӨӨРДӨГГҮЙ, ЭСВЭЛ БАТАЛГААГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХЫГ ЗӨВШӨӨРСӨН ЗААЛТУУД ОРУУЛАХЫГ ЗӨВШӨӨРДӨГ БАЙЖ БОЛОХ ЮМ. ТИЙМЭЭС ДЭЭРХ ХЯЗГААРЛАЛТ БУЮУ ХАСАЛТУУДЫН ЗАРИМ НЬ ТАНД ХАМААРАХГҮЙ БАЙЖ БОЛНО. ТАНЫ ХЭРЭГЛЭГЧИЙН ХУВЬД ЗААВАЛ ЭДЛЭХ ЁСТОЙ ХУУЛЬД ЗААСАН ЭРХҮҮДИЙН ХУВЬД ТАНЫГ ИЙМ ЭРХТЭЙ БАЙЖ БОЛНО ГЭЖ ҮЗЭЖ, ЭДГЭЭР ЭРХЭД НӨЛӨӨЛӨХГҮЙ.

Аливаа хэвшмэл заалтаас RIM татгалзаж байгаа нь ийм хэвшмэл заалтаас цаашид ч татгалзана гэсэн үг биш бөгөөд өөр бусад хэвшмэл заалтаас татгалзсан гэсэн үг биш.

Энэхүү хязгаарлагдмал баталгаа нь хуулийн зөрчлүүдийг шийдвэрлэхэд дагаж мөрддөг аливаа хуулийг эс тооцвол Англи, Вэльсийн хууль тогтоомжид захирагдаж, эдгээр хууль тогтоомжийн дагуу тайлбарлагдана. Энэхүү хязгаарлагдмал баталгааны талууд (цаашид хамтад нь “Талууд” гэх, дангаар нь “Тал” гэх) Улс хоорондын бараа худалдах, худалдан авах гэрээний тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенци бүтнээрээ энэхүү хязгаарлагдмал баталгаанд үйлчлэхгүй гэдэг дээр харилцан тохиролцов. Энэхүү хязгаарлагдмал баталгаанаас үүдсэн буюу энэхүү хязгаарлагдмал баталгаатай холбоотой үүссэн бүх санал зөрөлдөөн, маргааныг арбитрын шүүхээр эцэслэн шийдвэрлэнэ. Арбитрын шүүгчийн шийдвэр эцсийнх байх бөгөөд шийдвэрийг Талууд заавал биелүүлнэ (илэрхий алдаа гарах тохиолдлоос бусад үед). Арбитрын шүүгчийн шийдвэр бичгээр үйлдэгдэх бөгөөд үндэслэлүүдийг заасан байна. Арбитрын шүүгчийн тохиромжтой гэж үзэн шийдсэн хувь хэмжээгээр арбитрын шүүхийн зардлыг Талууд хуваан төлөхөөр арбитрын шийдвэрт заах ёстой. Танай улсын хуульд өөрөөр зааж, хориглоогүй бол арбитрын ажиллагаа дараах байдалтай явагдана: (i) Английн Лондон хотод явагдах; (ii) Английн хуулийн дагуу явагдах; (iii) англи хэлээр явагдах; (iv) Олон улсын худалдааны танхимын Арбитрын дүрмийн (цаашид “Дүрэм” гэх) дагуу шийдвэрлэх; ба (v) дээр дурьдсан Дүрмийн дагуу томилогдсон нэг арбитрын шүүгчээр хянагдах, ийнхүү арбитрын шүүгчийг томилсноос хойш 30 хоногийн дотор Талууд арбитрын шүүгчийн томилгоон дээр харилцан тохиролцох ёстой, ингэж харилцан тохиролцоогүй тохиолдолд

аль нэг тал өргөдөл гаргаж арбитрын ажиллагаа явуулах хүсэлт гаргах үед ажиллаж байгаа Британийн Компьютерийн Нийгэмлэгийн Ерөнхийлөгч (буюу Ерөнхийлөгч өөрийгөө төлөөлүүлэхээр томилсон хүн) арбитрын шүүгчийг томилно. Дээрхи заалтууд танай улсын хуулиар хориотой бол арбитрын ажиллагааг дараах байдалтай явуулна: (i) танай улсад явагдах; (ii) англи хэлээр явагдах; (iii) Дүрмийн дагуу арбитрын ажиллагаагаар шийдвэрлэгдэх; ба (iv) дээр дурьдсан Дүрмийн дагуу томилогдсон нэг арбитрын шүүгчээр хянагдах, ийнхүү арбитрын шүүгчийг томилсноос хойш 30 хоногийн дотор Талууд арбитрын шүүгчийн томилгоон дээр харилцан тохиролцох ёстой, ингэж харилцан тохиролцоогүй тохиолдолд төвийг сахисан тал арбитрын шүүгчийг томилно. Талуудын хоорондох буюу Танаас бусад аливаа этгээдийн оролцсон ямар ч маргааныг RIM-ээс урьдчилж бичгээр зөвшөөрөл авалгүйгээр нэгтгэж болохгүй.

Хэрэв энэхүү хязгаарлагдмал баталгааны нөхцлийг хүчингүй буюу хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл, энэхүү хүчингүй буюу хэрэгжүүлэх боломжгүй байдал нь нийт хязгаарлагдмал нөхцлийг хүчингүй буюу хэрэгжүүлэх боломжгүй болгохгүй, харин (түүнээс болж хянан үзэх ажиллагаа амжилтгүй болохгүй бол) хязгаарлагдмал баталгаа нь тодорхой хүчингүй буюу хэрэгжүүлэх боломжгүй заалт буюу заалтууд агуулаагүй гэж ойлгогдох бөгөөд Тал тус бүрийн эрх, үүргийг үүний дагуу ойлгож, хэрэгжүүлнэ.

Хэрэв энэ хязгаарлагдмал баталгааг англиас өөр хэл рүү орчуулбал англи хувилбар болон түүний орчуулгын хооронд утгын зөрөө гарсан тохиолдолд англи хэл дээрхи хувилбарыг баримтална.

Энэхүү хязгаарлагдмал баталгаа болон Дагалдах хэрэгслийн баглаа боодолд орсон аливаа баталгааны заалтууд хоорондоо зөрчилдвөл, энэхүү хязгаарлагдмал баталгааны заалтууд тухайн зөрчилтэй хэсэгт үйлчилнэ.

АНХААРУУЛГА: Энэ Дагалдах хэрэгслийг ЗӨВХӨН тохирох BlackBerry Handheld-тэй хамт хэрэглэх зориулалттай. Энэ Дагалдах хэрэгсэл таны BlackBerry Handheld-тэй таарч тохирох эсэхийг тогтоохын тулд Суурилуулах ба ашиглаж эхлэх тухай гарын авлага эсвэл Ашиглаж эхлэх тухай гарын авлагын аль байгааг нь үзэж танилцана уу. Өөр ямар нэг байдлаар хэрэглэвэл энэхүү Дагалдах хэрэгслийн хязгаарлагдмал баталгааг хүчингүй болгох бөгөөд энэ Дагалдах хэрэгслийг тохирох BlackBerry Handheld-ээс өөр ямар нэг төхөөрөмж буюу дагалдах хэрэгсэлтэй хамт хэрэглэснээс болж Танд буюу гуравдагч аливаа этгээдэд учирч болох аливаа хохирлыг RIM Таны өмнө буюу гуравдагч аливаа этгээдийн өмнө хариуцахгүй.

© 2008 Research In Motion Limited. Бүх эрх хамгаалагдсан. BlackBerry®, RIM®, Research In Motion®, SureType® ба холбогдох барааны нэр, нэр, лого зэрэг нь Research In Motion Limited-ийн өмч бөгөөд АНУ болон дэлхий дахины бусад улс оронд бүртгэгдэх ба/буюу хэрэглэгдэнэ.